



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Сүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 9 нэрийн нийт 24,574,900.00 (хорин дөрвөн сая таван зуун далан дөрвөн мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 21,780,000.00 (хорин нэгэн сая долоон зуун наян мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Говь-Сүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ш)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	GNSS станц	2017.12.31	1	19,500,000.00	19,500,000.00	19,500,000.00	2
2	Санхүүгийн программ	2017.01.01	1	880,000.00	880,000.00	880,000.00	2
3	Архивын сейф	2015.05.20	1	1,680,000.00	1,680,000.00	500,000.00	3
4	Дугуйтай тумбочка	2009.12.31	1	116,000.00	116,000.00	50,000.00	1
5	Компютерийн шар ширээ	2009.12.31	4	146,700.00	586,800.00	200,000.00	1
6	Улбар шар тумбочка	2009.12.31	1	157,300.00	157,300.00	50,000.00	1
7	Архивын шкаф	2015.08.01	1	1,332,800.00	1,332,800.00	500,000.00	1
8	Даргын бичгийн ширээ	2009.12.31	1	132,000.00	132,000.00	50,000.00	1
9	Даргын хурлын ширээ	2009.12.31	1	190,000.00	190,000.00	50,000.00	1
Нийт дүн					24,574,900.00	21,780,000.00	-
					(хорин дөрвөн сая таван зуун далан дөрвөн мянга есөн зуун)	(хорин нэгэн сая долоон зуун мянган төгрөг)	-